

Төмрийн хүдэр боловсруулж 52% агуулгатай төмрийн хуурай баяжмал үйлдвэрлэх ажлын техникийн даалгавар

№	Үзүүлэлтүүд	Тавигдах шаардлага
1	Ажлын зорилго	Баргилтын төмрийн хүдрийн уурхайн 32%-ийн агуулгатай төмрийн хүдрийг хуурай соронзон баяжуулах аргаар боловсруулж, F-52 маркийн төмрийн баяжмал үйлдвэрлэж нийлүүлэх
2	Оролцогчид тавигдах шаардлага	<ul style="list-style-type: none"> <li>- Өөрийн үйлдвэр болон газрын гэрчилгээтэй байх</li> <li>- Батлагдсан, хүчинтэй ТЭЗҮ</li> <li>- Үндсэн тоног төхөөрөмжүүдийн жагсаалт, зураг</li> </ul>
3	Үйлдвэрлэлд орох хүдрийн мэдээлэл	<ul style="list-style-type: none"> <li>- Нийлүүлэх хүдрийн хэмжээ: 300.000 мян.тн</li> <li>- Сард нийлүүлэх хүдрийн хэмжээ: 50,0 мян.тн-оос доошгүй</li> <li>- Төмрийн хүдрийн агуулга: &gt;32.0%</li> </ul>
4	Үйлдвэрлэлээс гарах бүтээгдэхүүнд тавигдах технологийн шалгуур үзүүлэлтүүд	<ul style="list-style-type: none"> <li>- Төмрийн баяжмалын агуулга 52,0 %-оос дээш, хүхрийн агуулга 1,5%-иас доош,</li> <li>- Төмрийн баяжмалын технологийн металл авалт 68,0 %-иас дээш байх,</li> <li>- Баяжмалын гарц: 42,5 %-иас дээш байх</li> <li>- Боловсруулалтаас гарсан завсрын бүтээгдэхүүнийг “Бор-Өндөр” УБҮ-т нийлүүлэх</li> <li>- Хоосон чулуулгын агуулга 6 %-оос хэтрэхгүй байх</li> </ul>
5	Бусад шалгуур үзүүлэлтүүд	<ol style="list-style-type: none"> <li>1. Байршил: Бор-Өндөр УБҮ, Баргилтын уурхайн районд байх</li> <li>2. Хүдэр болон баяжмалын агуулгыг “Бор-Өндөр” УБҮ-ийн химийн лабораторит тодорхойлно. Агуулга дээр талууд санал зөрсөн тохиолдолд хөндлөнгийн лаборатори /SGS/-ийн дүгнэлтийг гаргуулж шийдвэрлэнэ.</li> <li>3. Хүдэр, баяжмал, завсрын бүтээгдэхүүн болон хоосон чулуулгын жинг чийгшил тооцсон хуурай жингээр тооцож авна.</li> <li>4. Нийлүүлэх хүдрийг тусгай овоолго үүсгэж хүдрийн агуулгыг 2 талын төлөөллийн оролцоотойгоор тодорхойлж акт үйлдэж хүлээлцэнэ.</li> </ol>
6	Ажлын үр дүнг тайлагнах	<ul style="list-style-type: none"> <li>- Хоног тутам үйлдвэрлэлийн мэдээлэл тогтмол цагт гаргаж өгөх ба гарсан бүтээгдэхүүнийг лабораторийн шинжилгээгээр баталгаажуулж, хамтарсан акт үйлдэн шаардлага хангасан бүтээгдэхүүнийг “Бор-Өндөр” УБҮ-т нийлүүлж байх</li> </ul>

		- Сар бүрийн эцэст хамтарсан акт үйлдэж гэрээг дүгнэж байх
--	--	--